




ОРОЛЦОГЧТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ХӨТӨЛБӨР

Баримт бичгийн мэдээлэл	
Баримт бичгийн дугаар:	ЖР017
Баримт бичгийн хувилбарын дугаар:	1.0
Хүчин төгөлдөр болсон огноо:	2022.04.04
Мэдээллийн ангилал:	Нээлттэй
Хариуцагч	Дэд захирал

	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Баталсан:	Самдан овогтой Батжаргал	Гүйцэтгэх захирал	
Боловсруулсан:	Баянцогт овогтой Доржсэмбэ	Дэд захирал	

ӨӨРЧЛӨЛТИЙН ТҮҮХ

Хувилбар дугаар	Огноо (Он/Сар/Өдөр)	Боловсруулсан	Өөрчлөлтийн тайлбар	Хянагдсан	Баталсан
1.0	2022.04.04	Баянцогт овогтой Доржсэмбэ	Анхны хувилбар		

ТҮГЭЭЛТИЙН ЖАГСААЛТ

Хуулбарын дугаар	Түгээсэн /илгээсэн/ газар	Огноо	Гарын үсэг	Буцаасан	
				Огноо	Гарын үсэг
1.0	Нягтлан бодогчийн 000078 дугаарт шүүгээ	2022.04.04			

ИШЛЭЛ БАРИМТ БИЧГҮҮД

Д/д	Нэр	Дугаар/Огноо
1	Компанийн тухай хууль	2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр
2	Компаний засаглалын кодекс	2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр
3	Хөдөлмөрийн дотоод журам	ЖР001
4	Нууцын тухай журам	ЖР002

АГУУЛГА

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО	4
ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ.....	4
ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХЗҮЙН БАТАЛГАА	4
ДӨРӨВ. САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ ШИЙДВЭРЛЭХ.....	5

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДАЙ ХАРИЛЦАХ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО.

1.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Компанийн тогтвортой өсөлтийг хангах, үнэ цэнийг бий болгох, стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх, компанийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, оруулсан хөрөнгийг хамгаалах, компанийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, санал хүсэлтийг хүлээн авах, харилцан мэдээлэл солилцох, өөрийн бизнес, засаглал санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх бодит мэдээллийг хүргэхэд оршино.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ.

2.1. Хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилгоор Компани нь нээлтэй байдлаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх хэмжээ, хөрөнгө оруулалтын нөхцөл, стратеги төлөвлөгөө, зорилго, зорилт, компанийн түүх, танилцуулга, үйл ажиллагааны онцлог, давуу тал гэх мэт шаардлагатай мэдээллүүдээр цаг тухайд нь хангах ажиллагааг зохион байгуулах.

2.2. Хөрөнгө оруулагчдын санал бодол, шинэлэг санаа зэргийг хүлээн авах, хариу мэдэгдэх эргэх холбоосыг бүрдүүлэх зорилгоор мэдээлэл солилцох цахим хуудсыг нээн ажиллуулах, хөгжүүлэх.

2.3. Хөрөнгө оруулагчдыг их, бага хэмжээгээр хөрөнгө оруулсан гэж ялгаж үзэлгүй эрх тэгш байдлаар хандаж мэдээллийг жигд тэнцвэртэйгээр хангах.

2.4. Хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт хийх нөхцөл бололцоог хангах зорилгоор мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл болон бусад зуучлагч нарыг компанийн сайн засаглалд нэмэр оруулахуйц байдлаар үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.

2.5. Хөрөнгө оруулалтыг татах хэлбэрийг /хувьцаа, бонд, итгэлцэлийн үйлчилгээ/ хөрөнгө оруулахаар сонирхож буй этгээдэд нээлттэй хялбар байдлаар хэдийд ч хүргэх нөхцөл бололцоог бүрдүүлж, цахим хуудсыг ажиллуулах.

2.6. Цахим хуудсанд ТУЗ-ын дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын товч намтар, компанийн дүрэм, сүүлийн 5 жил хүртэлх санхүүгийн жилийн эцсийн тайлан үнэт цаасны арилжаа эрхлэгч болон зохицуулагч байгууллагад хүргүүлсэн тэдгээрээс хүлээж авсан чухал шийдвэр, мэдэгдэл, компанийн бүтэц, түүх, бизнесийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах зар, шийдвэр ногдол ашиг тараах огноо, гаргасан үнэт цаасны төрөл, холбогдох эрх, ногдол ашгийн бодлого болон тараасан мэдээлэл мэдээлэлтэй холбоотой гаргасан мэдэгдэл, үнэт цаасны бүртгэл хариуцсан этгээд, хаяг байршил, холбоо барих этгээдийн мэдээлэл зэргийг дэлгэрэнгүй байдлаар тавина.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХЗҮЙН БАТАЛГАА.

3.1. Хөрөнгө оруулагч нь Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хүрээнд өөрийн хөрөнгөө тодорхойлох нь аливаа эрсдлээс хамгаалах үндэс суурь болно.

3.2. Компанийн засаглалын тогтолцоо нь хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах болон эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлээд зогсохгүй, зөрчигдсөн эрхээ үр дүнтэйгээр нөхөн сэргээж авах боломжоор хангах.

3.3.Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглоно.

3.4.Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтыг дэмжих татварын болон татварын бус дэмжлэгийг эдлэх эрхтэй.

3.5.Компанид оруулсан хөрөнгө нь оруулсан хэлбэрээс шалтгаалан үнэт цаас, IPO буюу хувьцаа, бонд, итгэлцлийн үйлчилгээ зэрэг эрхзүйн үр дагавар бүхий харилцааг тус тусдаа нарийвчлан зохицуулсан гэрээ, дүрэм журам, хууль тогтоомжийн дагуу эрх нь хамгаалагдана.

ДӨРӨВ. САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ ШИЙДВЭРЛЭХ.

4.1.Хөрөнгө оруулагч нь компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор ямар нэгэн санал хүсэлт гаргах тохиолдолд компанийн цахим хаяг болон бичгээр санал хүсэлт гомдлоо гаргаж болно.

4.2.Хөрөнгө оруулагч нь санал хүсэлт болон гомдлоо гаргахдаа үндэслэл, овог, нэр, регистрийн дугаар, /хуулийн этгээд бол компанийн нэр, регистрийн дугаар/ санал хүсэлт гомдолыг хэрхэн шийдвэрлэсэн тухай буцаан хариу мэдэгдэх утасны дугаар, мэйл хаяг, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулдаг албан ёсны хаягийг тодорхой бичиж ирүүлнэ.

4.3.Санал хүсэлт, гомдлыг Компани нь хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа мэйл хаягаар болон холбогдох утсаар хариу мэдэгдэнэ.

4.4.Хөрөнгө оруулалтыг боловсронгуй болгох компанийн үйл ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх талаар санал хүсэлт гаргасан хөрөнгө оруулагчдын мэдээллийг судлаж үзэн компанид үр өгөөж өгөх санал хүсэлт бол хөрөнгө оруулагчийн саналыг үйл ажиллагаандаа шаардлагатай тохиолдолд ашиглаж болно.